

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.12	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	21
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БОГД ХААНЫ ОРДОН МУЗЕЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ЭРДЭНЭБААТАР ТАНАА

2019.02.25 № 02/292
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд хааны ордон музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Богд хааны ордон музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Богд хааны ордон музейн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Богд хааны ордон музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус музейн захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Эрдэнэбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд хааны ордон музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богд хааны ордон музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн “СМД аудит” ХХК-ийн аудитор Д.Гэндэнпэлжээ ахлагчтай аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Богд хааны ордон музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “СМД аудит” ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 5 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Богд хааны ордон музейн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Богд хааны ордон музей нь олон нийтэд нээлттэй, байнгын тасралтгүй үйл ажиллагаатай, халхын найман Богд, Монгол буддизм, ХХ зууны эхэн үеийн үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхтэй холбоотой гэрч болох соёлын өвийг цуглуулах, хадгалан хамгаалах, судлан шинжилж, сурталчлах, дэлгэн үзүүлэх, сэргээн засварлах, бүртгэн баримтжуулах төв байж, соёлын биет болон биет бус өвөөр дамжуулж нийгэмд нөлөөлөх байгууллага байхад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Богд хааны ордон музейн улсын бүртгэлийн гэрчилгээн дээр тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Музей, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үйл ажиллагаа

Богд хааны ордон музейн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Богд хааны ордон музейн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох

бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Богд хааны ордон музейн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 40 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Богд хааны ордон музей санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Гөү-Окей” ХХК-ийн “Explore” програм хангамж ашигладаг байна.

Богд хааны ордон музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Богд хааны ордон музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг тооцохдоо, төсвийн байгууллага тул 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Эрсдэл бага гэж үзсэн учир, материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар сонгох нь зүйтэй гэж үзэв.

Богд хааны ордон музейн 2018 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 619,332.9 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 6,193.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 10 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 9 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	25,374.7	
	Дүн	1	25,374.7	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудалд зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын 2.2-т заасны дагуу салбар комисс музейн үзмэрийн тооллогын ажлыг хийж байна. Тооллогод нийт 4 төрлийн сан хөмрөгт хамаарагдах 4209 дэсийн 8639 ширхэг үзмэр хамрагдах ёстой бөгөөд өнөөдрийн байдлаар 1835 дэсийн 7033 ширхэг үзмэр тоологдож, тооллогын ажил 81.4 хувьтай явагдаж байна.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын хамгаалалтын бүсэд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, 38.1.2, 45 дугаар зүйлийн 45.3.1, 45.3.3, 45.3.7-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан тул “Вантрейд” ХХК-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээг Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/439 дугаар захирамжаар хүчингүй болгосон байна. Үүнтэй холбоотойгоор “Вантрейд” ХХК-ийн шүүхэд гаргасан нэхэмжлэл 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Дээд шүүхээс Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх рүү буцааж, одоогоор шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй байна.

Дараагийн аудитаар дээрх музейн үзмэрийн улсын тооллогын дүн болон газартай холбоотой шүүхийн маргааны эцсийн шийдвэрийг авч үзэх шаардлагатай.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Богд хааны ордон музейн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 44 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 397,992.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Богд хааны ордон музей Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 147 мэдээллийг хугацаанд нь 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5.0 сая

төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 21 гүйлгээ байгааг тайлант хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж, 1 акт, 1 албан шаардлага өгсөн бөгөөд акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь хэрэгжсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Богд хааны ордон музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Богд хааны ордон музейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж зөрчилгүй санал дүгнэлт гаргалаа.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Богд хааны ордон музейн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актын дүнтэй тулгахад 22,000.0 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардал, 3,374.7 мянган төгрөгийн авлагыг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй.

3.1.2 Эрсдэл:

Авлага их хэмжээгээр найдваргүй болох, батлагдсан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, хэрэглэгч, удирдлага үнэн зөв мэдээлэл авах боломжийг хязгаарлах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “ерөнхий нягтлан бодогч эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах үүрэгтэй” гэж заасны дагуу өр, авлагын тооцоо нийлсэн актыг баталгаажуулан, тодруулга тэмдэглэлийг стандарт шаардлагын дагуу иж бүрэн толилуульж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өр, авлагын тооцоо нийлсэн актыг баталгаажуулан, тодруулга тэмдэглэлийг стандарт шаардлагын дагуу иж бүрэн толилуульж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	136,485,528.86	279,993,114.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,334.00	6,734.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	9,334.00	6,734.00
31110	Төгрөг	9,334.00	6,734.00
33	АВЛАГА	52,155,361.53	52,080,166.08
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	166,630.53	60,200.08
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	13,783,000.00	2,614,600.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	39,097,916.00
335	Бусад авлага	38,205,731.00	10,307,450.00
3351	Байгууллагаас авах авлага	38,205,731.00	10,307,450.00
34	УРЬДЧИЛГАА	9,470,000.00	68,884,800.00
34600	Урьдчилж гарсан зардал	9,470,000.00	68,884,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	74,850,833.33	159,021,414.33
351	Түүхий эд материал	-	139,800.00
35130	Эм боох материал	-	139,800.00
354	Хангамжийн материал	74,850,833.33	158,881,614.33
35410	Бичиг хэргийн материал	1,357,739.00	4,588,122.00
35420	Аж ахуйн материал	31,991,542.33	60,963,722.33
35430	Сэлбэг хэрэгсэл	-	135,000.00
35470	Бусад хангамжийн материал	41,501,552.00	93,194,770.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,900,433,521.66	17,642,745,387.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,900,433,521.66	17,642,745,387.50
392	Биет хөрөнгө	15,884,433,521.75	16,529,167,187.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,522,593,317.35	2,028,891,829.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	-606,045,203.93	-488,781,258.98
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,077,777.78	20,077,777.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,221,759.02	-16,731,481.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	308,853,226.35	311,030,434.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-189,651,089.85	-174,136,973.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	205,380,381.88	204,207,069.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	-160,540,722.80	-156,161,803.47
39213	Түүх соёл, музейндурсгалт зүйлс	14,785,597,927.99	14,785,597,927.99
39217	Ном	12,389,666.00	15,173,666.00
393	Биет бус хөрөнгө	15,999,999.91	1,113,578,199.88
39301	Програм хангамж	19,420,000.00	20,740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,420,000.09	-4,520,000.12
39303	Бусад биет бус хөрөнгө	-	1,097,358,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	16,036,919,050.52	17,922,738,501.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,375,683.59	4,988,261.84
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,375,683.59	4,988,261.84
413	Өглөг	9,375,683.59	4,988,261.84
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	276,349.59	170,907.84
4136	Бусад өглөг	9,099,334.00	4,817,354.00
41361	Байгууллагад төлөх өглөг	9,090,000.00	4,547,300.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	9,334.00	270,054.00

Богд хааны ордон музейн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>16,027,543,366.93</u>	<u>17,917,750,240.07</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	16,027,543,366.93	17,917,750,240.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,285,020,112.91	4,382,378,312.91
51101	Өмч:- төрийн	3,285,020,112.91	4,382,378,312.91
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	-40,264,914.45	55,514,727.97
51210	Өмнөх үеийн үр дүн	-172,849,359.56	-40,264,914.45
51220	Тайлант үеийн үр дүн	132,584,445.11	95,779,642.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,782,788,168.47	13,479,857,199.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>16,036,919,050.52</u>	<u>17,922,738,501.91</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	727,756,502.50	619,332,909.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	446,258,842.50	228,964,518.00
120	Нийтлэг татварын бус орлого	446,258,842.50	190,129,722.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	446,258,842.50	189,968,919.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	305,938,760.00	186,027,369.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,015,661.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	129,304,421.50	3,941,550.00
120009	Бусад орлого	-	160,803.00
122	Тусламжийн орлого	-	38,834,796.00
122002	Хандив тусламж /гадаад/	-	38,834,796.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	281,497,660.00	390,368,391.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	183,018,000.00	225,399,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	183,018,000.00	225,399,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,479,660.00	164,968,891.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,442,280.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	98,479,660.00	163,526,611.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	595,172,057.39	479,623,213.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	595,172,057.39	479,623,213.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	542,450,854.23	425,031,892.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,576,611.30	170,467,313.93
210101	Үндсэн цалин	171,576,611.30	137,320,121.78
210102	Нэмэгдэл	-	4,781,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	14,943,000.00
210104	Урамшуулал	-	13,422,592.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,127,178.47	22,280,139.45
210201	Тэтгэврийн даатгал	12,193,717.47	15,054,158.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,413,565.00	1,494,772.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,515,478.00	1,695,874.39
210204	Ажилгүйдлийн даатгал	559,288.00	373,693.20
210205	Эрүүл мэндийн даатгал	3,445,130.00	3,661,640.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,422,670.46	32,958,931.96
210301	Гэрэл, цахилгаан	11,768,360.00	14,807,188.00
210302	Түлш, халаалт	20,736,627.00	16,840,634.00
210303	Цэвэр, бохир ус	1,917,683.46	1,311,109.96
2104	Хангамж, бараа материалын зардал	15,054,136.97	39,120,598.40
210401	Бичиг хэрэг	2,326,718.00	2,719,777.00
210402	Тээвэр, шатахуун	667,700.00	2,295,117.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,247,336.97	2,403,239.40
210404	Ном, хэвлэл	-	10,201,484.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,954,080.00	2,334,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,598,754.00	18,731,851.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	259,548.00	435,050.00
2105	Нормативт зардал	739,050.00	21,950.00

**Богд хааны ордон музейн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	21,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	739,050.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,244,203.00	1,014,160.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,980.00
210604	Урсгал засвар	20,244,203.00	1,012,180.00
2107	Томилолт, зочны зардал	555,700.00	1,210,000.00
210702	Дотоод албан томилолт	555,700.00	1,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,221,396.64	90,119,737.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,868,006.64	76,084,117.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,959,400.00	9,965,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,300.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	88,000.00
210807	Газрын төлбөр	2,982,382.00	2,982,320.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,356,308.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	202,509,907.39	67,839,061.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,479,660.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,030,247.39	67,839,061.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,721,203.16	54,591,320.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,931,884.56	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,931,884.56	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,789,318.60	53,091,320.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,789,318.60	53,091,320.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>132,584,445.11</u>	<u>139,709,695.74</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	43,930,053.32
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	-	43,930,053.32
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-43,930,053.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>132,584,445.11</u>	<u>95,779,642.42</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>594,712,645.80</u>	<u>629,845,079.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	313,214,985.80	239,476,688.00
120	Нийтлэг татварын бус орлого	313,214,985.80	200,641,892.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	313,214,985.80	200,308,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	291,257,260.00	200,308,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,957,725.80	-
120009	Бусад орлого	-	333,492.00
122	Тусламжийн орлого	-	38,834,796.00
122002	Хандив тусламж /гадаад/	-	38,834,796.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	281,497,660.00	390,368,391.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	183,018,000.00	225,399,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	183,018,000.00	225,399,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,479,660.00	164,968,891.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,442,280.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	98,479,660.00	163,526,611.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>552,283,681.80</u>	<u>574,135,479.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,283,681.80	574,135,479.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	491,217,032.64	480,446,242.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,911,736.82	170,638,221.78
210101	Үндсэн цалин	138,547,285.97	137,320,121.78
210102	Нэмэгдэл	-	4,781,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,093,500.00	14,943,000.00
210104	Урамшуулал	12,270,950.85	13,593,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,263,404.59	22,173,709.00
210201	Тэтгэврийн даатгал	16,353,417.94	14,947,727.94
210202	Тэтгэмжийн даатгал	599,715.17	1,494,772.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	720,114.23	1,695,874.39
210204	Ажилгүйдлийн даатгал	149,928.80	373,693.20
210205	Эрүүл мэндийн даатгал	1,440,228.45	3,661,640.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,422,670.46	32,958,931.96
210301	Гэрэл, цахилгаан	11,768,360.00	14,807,188.00
210302	Түлш, халаалт	20,736,627.00	16,840,634.00
210303	Цэвэр, бохир ус	1,917,683.46	1,311,109.96
2104	Хангамж, бараа материалын зардал	9,548,956.97	31,335,296.40
210401	Бичиг хэрэг	1,663,707.00	5,180,060.00
210402	Тээвэр, шатахуун	667,700.00	2,024,117.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,247,336.97	2,838,239.40
210404	Ном, хэвлэл	-	11,940,000.00

**Богд хааны ордон музейн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,954,080.00	2,334,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,016,133.00	7,018,800.00
2105	Нормативт зардал	6,505,450.00	1,844,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,505,450.00	1,844,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,550,140.00	51,725,080.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,959,950.00	1,784,320.00
210604	Урсгал засвар	21,590,190.00	49,940,760.40
2107	Томилолт, зочны зардал	555,700.00	1,210,000.00
210702	Дотоод албан томилолт	555,700.00	1,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	119,009,426.00	168,560,703.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	103,527,344.00	139,841,683.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,959,400.00	9,900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,300.00	65,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	341,400.00
210807	Газрын төлбөр	2,982,382.00	2,982,320.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,485,000.00	14,430,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,449,547.80	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,449,547.80	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,066,649.16	93,689,236.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,277,330.56	1,500,000.00
213204	Ажил олгогчоос олгохбусад тэтгэмж, урамшуулал	969,400.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,045,446.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,262,484.56	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,789,318.60	92,189,236.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,789,318.60	92,189,236.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>42,428,964.00</u>	<u>55,709,600.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	42,419,630.00	55,712,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,419,630.00	55,712,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	42,419,630.00	55,712,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,419,630.00	55,712,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-42,419,630.00</u>	<u>-55,712,200.00</u>
5	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,334.00	-2,600.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,334.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,334.00	6,734.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,285,020,112.91	12,782,788,168.47	-172,893,216.56	15,894,915,064.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	43,857.00	43,857.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,285,020,112.91	12,782,788,168.47	-172,849,359.56	15,894,958,921.82
Тайлант үеийн үр дүн	-	-	132,584,445.11	132,584,445.11
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,285,020,112.91	12,782,788,168.47	-40,264,914.45	16,027,543,366.93
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,285,020,112.91	12,782,788,168.47	-40,264,914.45	16,027,543,366.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,285,020,112.91	12,782,788,168.47	-40,264,914.45	16,027,543,366.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		697,069,030.71	-	697,069,030.71
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	1,097,358,200.00	-	-	1,097,358,200.00
Тайлант үеийн үр дүн	-	-	95,779,642.42	95,779,642.42
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,382,378,312.91	13,479,857,199.18	55,514,727.97	17,917,750,240.07

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,334.00	-	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	397,992,600.00	372,689,571.54	25,303,028.46	93.64
УРСГАЛ ЗАРДАЛ	397,992,600.00	372,689,571.54	25,303,028.46	93.64
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,992,600.00	372,689,571.54	25,303,028.46	93.64
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,266,380.00	157,778,821.78	1,487,558.22	99.07
Үндсэн цалин	137,874,600.00	137,320,121.78	554,478.22	99.60
Нэмэгдэл	4,781,680.00	4,781,600.00	80.00	100.00
Унаа хоолны хөнгөлөлт	15,876,000.00	14,943,000.00	933,000.00	94.12
Урамшуулал	734,100.00	734,100.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,111,910.00	19,839,580.00	-727,670.00	103.81
Тэтгэврийн даатгал	12,741,300.00	13,955,486.53	-1,214,186.53	109.53
Тэтгэмжийн даатгал	1,592,660.00	1,494,772.79	97,887.21	93.85
ҮОМШӨ-ний даатгал	1,274,100.00	727,680.00	546,420.00	57.11
Ажилгүйдлийн даатгал	318,610.00	-	318,610.00	0.00
Эрүүл мэндийн даатгал	3,185,240.00	3,661,640.68	-476,400.68	114.96
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,731,230.00	32,958,931.96	15,772,298.04	67.63
Гэрэл, цахилгаан	20,046,000.00	14,807,188.00	5,238,812.00	73.87
Түлш, халаалт	22,771,950.00	16,840,634.00	5,931,316.00	73.95
Цэвэр, бохир ус	5,913,280.00	1,311,109.96	4,602,170.04	22.17
Хангамж, бараа материалын зардал	14,864,760.00	14,245,296.40	619,463.60	95.83
Бичиг хэрэг	2,830,460.00	2,709,760.00	120,700.00	95.74
Тээвэр, шатахуун	2,304,600.00	2,024,117.00	280,483.00	87.83
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,745,060.00	2,538,239.40	206,820.60	92.47
Ном, хэвлэл	620,000.00	620,000.00	-	100.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,564,700.00	2,334,080.00	230,620.00	91.01
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,799,940.00	4,019,100.00	-219,160.00	105.77
Аж ахуйн материал худалдан авах зардал			-	
Нормативт зардал	1,774,200.00	1,544,300.00	229,900.00	87.04
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,774,200.00	1,544,300.00	229,900.00	87.04
Эд хогшил, урсгал засварын зардал	12,047,300.00	11,996,918.40	50,381.60	99.58
Багаж, техник, хэрэгсэл	1,800,000.00	1,784,320.00	15,680.00	99.13
Урсгал засвар	10,247,300.00	10,212,598.40	34,701.60	99.66
Томилолт, зочны зардал	1,940,000.00	1,210,000.00	730,000.00	62.37
Дотоод албан томилолт	1,940,000.00	1,210,000.00	730,000.00	62.37

**Богд хааны ордон музейн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	140,256,820.00	133,115,723.00	7,141,097.00	94.91
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	122,199,500.00	116,826,753.00	5,372,747.00	95.60
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	9,900,000.00	9,900,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	122,000.00	65,300.00	56,700.00	53.52
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	510,000.00	341,400.00	168,600.00	66.94
Газрын төлбөр	4,525,320.00	2,982,320.00	1,543,000.00	65.90
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000,000.00	1,999,950.00	50.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	397,992,600.00	372,686,971.54	25,305,628.46	93.64
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	225,399,500.00	186,803,200.54	38,596,299.46	82.88
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	172,593,100.00	185,883,771.00	-13,290,671.00	107.70
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	172,593,100.00	185,883,771.00	-13,290,671.00	107.70
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,334.00	-9,334.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,734.00	-6,734.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
Төсвийн байгууллага	1	1	-	100.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	-	100.00
Удирдах ажилтан	1	1	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	7	12	-5	171.43
Үйлчлэх ажилтан	13	8	5	61.54
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	21	-	100.00
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	16	13	3	81.25
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	8	-3	160.00

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	164,968,871.00	-164,968,871.00	
УРСГАЛ ЗАРДАЛ	-	164,968,871.00	-164,968,871.00	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	163,468,871.00	-163,468,871.00	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	12,859,400.00	- 12,859,400.00	
Урамшуулал	-	12,859,400.00	- 12,859,400.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,334,129.00	- 2,334,129.00	
Тэтгэврийн даатгал	-	992,241.41	-992,241.41	
ҮОМШӨ-ний даатгал	-	968,194.39	-968,194.39	
Ажилгүйдлийн даатгал	-	373,693.20	-373,693.20	
Хангамж, бараа материалын зардал	-	19,240,000.00	-19,240,000.00	
Бичиг хэрэг	-	2,500,300.00	- 2,500,300.00	
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	300,000.00	-300,000.00	
Ном, хэвлэл	-	13,440,000.00	-13,440,000.00	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,999,700.00	- 2,999,700.00	
Нормативт зардал	-	300,000.00	-300,000.00	
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	300,000.00	-300,000.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	-	89,615,762.00	-89,615,762.00	
Багаж, техник, хэрэгсэл	-	41,525,800.00	-41,525,800.00	
Тавилга	-	8,361,800.00	- 8,361,800.00	
Урсгал засвар	-	39,728,162.00	-39,728,162.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	39,119,580.00	-39,119,580.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	24,369,530.00	-24,369,530.00	
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,000,000.00	-1,000,000.00	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,320,000.00	-1,320,000.00	
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	12,430,050.00	-12,430,050.00	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,500,000.00	-1,500,000.00	
Бусад урсгал шилжүүлэг	-	1,500,000.00	-1,500,000.00	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,500,000.00	-1,500,000.00	

Богд хааны ордон музейн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	38,834,796.00	- 38,834,796.00	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	164,968,871.00	-164,968,871.00	
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	164,968,871.00	-164,968,871.00	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	164,968,871.00	-164,968,871.00	
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Богд хааны ордон музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	Аудитын код:
2019.02.22			САГ-2019/379/ СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Богд хааны ордон музей		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7
1	Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актын дүнтэй тулгахад 22,000.0 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардал, 3,374.7 мянган төгрөгийн авлага тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	25,374.7	Зөвлөмж			Захирлын үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	Ц.Эрдэнэбаатар Б.Эрдэнэчимэг
Нийт		25,374.7					